



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 1/24

Улаанбаатар хот

Ур чадварын нэмэгдэл олгох  
тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1.8 дугаар зүйл заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 9.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын ажилтнуудын ажлын бүтээмжээс хамаарч 2018 оны 06 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг хуулийн дагуу олгосугай.
2. Ажлын бүтээмжийг Ур чадварыг дүгнэх журмын дагуу тооцон батлуулахыг Ахлах мэргэжилтэн /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу ур чадварын нэмэгдлийг олгохыг Ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ



D:\ariukaa\tushaal\2018\tushaal-A.doc